



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ  
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/429


Рашаант

Баталгаажсан үүлдэр, омгийн бог малын  
хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах,  
ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/549 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр баталгаажсан үүлдэр омгийн бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үзлэг ангилалт хийх төсвийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сумын хэмжээнд үржилд ашиглаж байгаа бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлт хийх ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 15-аас 10 дугаар сарын 15-ны дотор хийж гүйцэтгэж, 10 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг ХАА-н тасгийн дарга /А.Семейхан/-д үүрэг болгосугай.
3. Баталгаажсан үүлдэр омгийн малын хээлтүүлэгчийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, Мал үржлийн технологийн ажил үйлчилгээний нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулж, ажлын дүнг нэгтгэн 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор тайлагнахыг МААБМэдээлэл хариуцсан мэргэжилтэн /С.Хуандых/-д даалгасугай.
4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга /С.Аманкелд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.СЕРИКБОЛ